

Уур амьсгалын өөрчлөлт ба цөлжилт

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас улам бүр эрчимжиж байгаа цөлжилт бол байгалийн өмнө тулгарч байгаа өнөө цагийн хамгийн аугаа их сорилтын нэг мөн.




Цөлжилт гэдэг нь уур амьсгалын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн улмаас гандуу хуурай бүс нутагт явагдаж буй газрын доройтолыг юм. Монгол оронд сүүлийн 70 жилийн хугацаанд жилийн агаарын дундаж температур 2.14 оС дулаарчээ (дэлхийн дулаарлын дундаж 0.7оС. Уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас нийт нутаг дэвсгэрийн 73% цөлжилтөнд өртөөд байна (Геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны төв).

Нүүрстөрөгчийн хөрсөн дахь агууламжийг нэмэгдүүлснээр агаар мандал дахь CO_2 -ийн хэмжээ багасч, үр шим ихтэй газар бий болно.

Хүн төрөлхтөн олон арван жилийн турш байгалийн онцгой үр дагавар бүхий аюул хөнөөл ихтэй үзэгдлийн битүү цагиргийг/тойргийг бий болгох үйл ажиллагааг явуулж байна. Хүлэмжийн хийг ялгаруулж агаар мандлыг доройтуулснаар газрын доройтол ч ихэсч байна. Энэ нь цаашлаад агаар мандлын доройтлыг ч улам муудуулж байгаа юм.

Аж үйлдвэржилтийн үсрэнгүй хөгжлөөр жигүүрлэсэн хүн төрөлхтөний үйл ажиллагааны улмаас агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламж сүүлийн хоёр зуу орчим жилийн турш байнга ихсэж байна. Хөдөө аж ахуйн үеэ өнгөрөөсөн технологи, арга ажиллагааны улмаас нүүрлэсэн газрын доройтол эргээд хүлэмжийн хийг нэмэгдүүлж байна.



Дэлхий даяар улс орнууд өөрсдийн Засгийн газар болон төрийн бус байгууллагаар дамжуулан автомашин, үйлдвэр, цахилгаан станцуудын ялгаруулах нүүрсхүчлийн хийнд хязгаарлалт тогтоож байгаа хэдий ч CO_2 -г газарт шингээж "дахин хэрэглэх" аргад анхаарал хандуулахгүй байна, мөн олон улсын дэмжлэг тусламж ч үүнийг анхаарахгүй байна. Хөрсөн дахь органик нүүрстөрөгч нь агаар мандалд CO_2 хэлбэрээр байгаа, мөн ургамлын нөмрөгт агуулагдах нүүрстөрөгчийг нийлүүлснээс илүү хэмжээтэй байдаг баримт нь олон нийтийн анхааралд өртөхгүй байна, мөн хүлээн зөвшөөрөгдөөгүй байна (Зураг 1-ийг харна уу).

Нүүрстөрөгчийг шингээх үйл явц гэдэг нь CO_2 -г шингээх байдлаар (байгалийн явцаар нь ба хүний оролцоотойгоор) агаар мандал дахь нүүрсхүчлийн хийг голдуу хөрсөн дахь ургамлын органик бодис болгож зайлуулах явдал юм. Хөрсний нүүрстөрөгчийн шингээлт нь агаар мандал дахь нүүрсхүчлийн хийг зайлуулж дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах чухал бөгөөд хурдацтай арга болно. Органик аргаар боловсруулсан хөрс нь нүүрсхүчлийн хий хэмээх хүлэмжийн хийг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх чухал түүхий эд болгон хувиргадаг. Газар тариалангийн зориулалтаар ашиглаагүй байгаа хөрсөнд шингэсэн нүүрстөрөгчийн хэмжээг хэрвээ нийлүүлбэл нийт газар нь тэр чигээрээ нүүрстөрөгчийн агуулах болж хүлэмжийн хийг шингээгч болгох боломж нь зүйрлэшгүй их юм.

Энэ бүхэн нь газрыг илүүдэл CO_2 -г шингээгч, дэлхийг хөргөөгч гэсэн шинэ ач холбогдолтой болоход ихээхэн хувь нэмэртэй юм. Ус ба нарны боломжтой нийлүүлбэл CO_2 нь хөрсийг улам баяжуулж, ногоон ургамлыг тэтгэх ба үүнээс улбаалаад ургамал ч өөрөө нүүрстөрөгчийг шингээх боломжтой байх юм.



Гэсэн хэдий ч хөрсний хэмжээ ямар нэгэн байдлаар хаа нэгтээ хорогдоход хүрвэл хөрсний нүүрстөрөгчийг шингээх үйл ажиллагаа ЗОГСОХ БОЛНО. Хөрсний алдагдал, хорогдлын асуудлыг хүлээн зөвшөөрөх явдал нь анхны алхам юм. Үүний талаар ямар нэг зүйл хийж түүний нүүрстөрөгчийг шингээх үйл явцыг ДАХИН ЭХЛҮҮЛЭХ нь дараагийн алхам болно. Ийнхүү энэ бүхнийг цогцоор нь авч үзвэл уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи хэлэлцээрт оролцож байгаа мэргэжилтнүүд одоогийн байдлаар бараг хэлэлцэхгүй шахам байгаа газар, хөрсний сэвдийг голлох сэдэв болгон авч үзэх шаардлагатай байна.

Байгаль орчны хямралт байдал дэлхийн хамгийн ядуу, эзмэг бүлэгт хамгийн их нөлөө үзүүлэх болно

Цөлжилт гэдэг нь уур амьсгалын хэлбэлзэл, хүний үйл ажиллагаа зэргээс үүдэх хуурай гандуу газар нутаг дахь газрын доройтол юм. Уур амьсгалын өөрчлөлт нь бүх дэлхийд нөлөөлдөг хэдий ч үүнд хүн амын хамгийн ядуу давхарга хамгийн ихээр өртдөг. Мянганы экосистемийн үнэлгээ (2005) -гээр хуурай гандуу газар нутагт амьдарч байгаа ард түмэн эдийн засгийн хувьд хамгийн хүнд дорой нөхцөлд байдаг байна. Хуурай гандуу бүс нутгийн тухайд нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээгээр хамгийн доогуурт, нярай хүүхдийн эндэгдлээр хамгийн дээгүүрт бичигддэг. Энэ бүх асуудлыг хуурай гандуу газар нутгийнх нь доройтол улам нэрмэж байдаг. Хөрсний үржил шим муудсанаар ургацын хэмжээ багасаж, тэр хэмжээгээрээ орлогын нэмэлт эх үүсвэрт ч нөлөөлнө.

Газрын доройтол нь байгаль орчны доройтол, ядуурал, хүн амын шилжилт хөдөлгөөн, зөрчилт байдал зэрэг битүү цагиргийг бий болгож үүний нөлөөнд байгаа улс орнууд, бүс нутгуудын тухайд улс төрийн тогтвортой байдалд нь аюул учруулна.

Хуурай гандуу газар нутагт хэдийгээр ийм хүнд асуудал ихээхэн хуримтлагдсан байдаг ч НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц энэ бүсийн хөгжих бололцоог өндөр гэж үздэг. Энэ бүс нутаг нь байгалийн баялагийг ихээхэн хэмжээгээр нийлүүлдэг бөгөөд дэлхийн мал тэжээмэл амьтны 50 хувь нь энд байршдаг байна. Газрын тогтвортой менежментийн шинэ загвар нь зах зээлийн байнга өөрчлөгдөж байдаг эрэлт хэрэгцээнд дасан зохицох, уламжлалт технологийг ашиглаж орлогын эх үүсвэрийг бий болгох, амьдралынхаа чанарыг дээшлүүлэх, экосистемийг хамгаалах зэрэг үйлдлээр хариу барих боломжийг газар ашиглагчид олгож байна.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх тэмцэлд хөрс өөрчлөлт гаргаж чадна

Уур амьсгалын өөрчлөлт ба газар, хөрс хоорондын холбоо руу анхаарлаа хандуулах явдлыг нэмэгдүүлсэнээр нүүрстөрөгчийг шингээх бие даасан, зарчмын шинж чанартай мэтгэлцээнийг баяжуулаад зогсохгүй, хөгжиж буй улс орныг дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах асуудалд оролцоход нь тус болохуйц шинэ бөгөөд маш сонирхолтой тавцанг бий болгоно. Хөгжиж байгаа улс орны олонхийнх нь тухайд, хөрс бол хамгийн чухал байгалийн баялаг нь юм. Урагш алхах нэгэн баттай хэлбэр бол цэвэр хөгжлийн механизмийг газар тариалангийн тухайд газрыг ашиглаж байгаа хэлбэр байдлаар өргөтгөх, хөрсөнд нүүрстөрөгчийг шингээхэд чиглэсэн төслийг хэрэгжүүлэх явдал юм. Ийм төсөл нь хөрсний үржил шимд үзүүлэх

нөлөөнийхөө тухайд ихээхэн нэмэлт ач холбогдолтой байх юм.

Ирээдүйд шийдвэрлэвэл зохих нэг сорилт бол зөвхөн хүлэмжийн хийн ялгаралтыг багасгаснаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэнэ гэсэн ойлголтоос салах асуудал юм. Газар ба хөрсний асуудлаар байгуулсан байгаль орчны олон улсын цорын ганц гэрээ болохынхоо хувьд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл явцад ихээхэн хувь нэмэр оруулах чадвартай гэрээ хэлэлцээр юм. Конвенцийн Шинжлэх ухаан, технологийн комиссоос үндэсний, дэд бүсийн, бүсийн, дэлхийн түвшний хэмжээнд дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх харилцан уялдаа бүхий үзүүлэлтийг нэвтрүүлж эхлээд байна. Конвенцид нэгдэн орсон 193 улс орон хамтаараа газрын доройтлоос сэргийлэх, үүнд хохирсон менежментийг хэрэгжүүлэх, хариу арга хэмжээ авах бодлого, үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай бүх дэлхийг бүрхсэн тогтолцоог бүрдүүлж байгаа бөгөөд үүгээрээ маш чухал үүргийг гүйцэтгэх чадвартай юм.

Рио-гийн конвенцүүд гэж нэрлэгдэх Биологийн төрөл зүйлийн тухай Конвенц, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь конвенц нь 1992 онд байгуулагдсан Хамтын ажиллагааны нэгдсэн бүлэг (Joint Liaison Group, JLG)-ийн тусламжтайгаар уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох үйл ажиллагаа, цөлжилттэй тэмцэх тэмцэл, биологийн олон янз байдлын хамгаалал, байгалийн баялгийн тогтвортой хэрэглээний элементүүдийг хооронд нь уялдуулснаар гурван конвенцийн хоорондынх нь уялдаа холбоо (синерги), хамтын ажиллагааг улам бүр сайжруулахаар ажиллаж байна. Рио-гийн конвенцүүд нь тус бүрийнхээ авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхийн тулд харилцан уялдсан, бие биенээ нөхсөн буюу синержитик байдлаар ажиллахад зохицсон үйл ажиллагааг өдөөгч, түүнийг улам бүр дэмжигч хүч болж ажиллах чадвартай билээ.

Судалгаагаар уур амьсгал ба газрыг хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай нийт зардалын хэмжээ нь эс үйлдлийн улмаас үүсэх хохирлыг арилгахад шаардлагатай зардлаас хамаагүй бага гарна гэжээ. Уур амьсгал ба газрыг хамгаалах асуудлыг шийдвэрлэхүйц өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг бий болгоход олон улсын нэгдсэн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.

Энэхүү Конвенц нь бидний өмнө тулгарч байгаа сорилт буюу уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлтэй тэмцэхэд дасан зохицох, нөлөөллийг бууруулах, үүнийг сөрөн зогсоход шаардлагатай олон улсын хөрсний тогтоц/суурь баримт бичиг юм.

